

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2017.06.28

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжил тийн хувь
1	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг сурталчлан, тэмдэглэн өнгөрүүлэх	-Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн гишүүдийг хамруулан зохион байгуулах -Хөтөлбөр, төлөвлөгөө батлуулсан байх	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулагдан, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллалаа. Хөтөлбөрийн дагуу хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн гишүүд, “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ-тэй хамтран “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” уриан дор зохион байгууллаа Аж ахуй нэгж, байгууллагууд, сурагчдын төлөөлөл оролцсон “Хүүхэд бидний ирээдүй” баярын жагсаал төв талбайд ирснээр баярын нээлтийн үйл ажиллагаа эхэллээ. Баярын жагсаалыг Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн гишүүд тэргүүлж, Сайнцагаан сумын шилдэг хүүхдүүд, оролцооны байгууллагын хүүхдүүд, Улсын бүртгэлийн хэлтэс, Орон нутгийн өмчийн алба, Авто тээврийн төв, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Цахилгаан түгээх сүлжээ салбар, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ, “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театр, Төв халхын дуулалт жүжгийн театр, Сайнцагаан сумын ЗДТГ, Музей, Ус цаг уур орчны шинжилгээний алба, Холбооны газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн	100%

			газар, ЭДЦС, ГИЦС, МГСС, Хүмүүнлэг сургааль, “Дэлхийн зөн” Дундговь ОНХХ, Улаан загалмайн хороо нийт 23 байгууллага жагсаж, хүүхдийн үндсэн эрхийг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход байгууллага хамт олноороо нэгдлээ. Тус үйл ажиллагааг зохион байгуулснаар хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр олон нийтийн ойлголт нэмэгдэж, мэдээлэлтэй болсон. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн гишүүн байгууллагууд Г.Чагдаржавын талбайд “Дээс дээс үсрээрэй”, “Илжигдэх”, “Хос шоо”, “Сансрын нисгэгч”, “Бяцхан АХА-чид”, “Бүжигчин тахиа”, “Дэлдэн туулайны ертөнц”, “Шидэт давцан” гэсэн тоглоомын 8 өртөө ажиллуулж, нийт 457 хүүхэд 64 гэр бүлийг хамруулан ажиллав. Мөн энэ үеэр насны ангиллаар дугуйн уралдаан, “Миний ертөнц” талбайн зургийн уралдаан, “Гурвын эсрэг гурав” сагсан бөмбөгийн тэмцээнүүд зохион байгуулагдлаа.	
2	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймгийн салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх	-Сард 2 удаа зөвлөлийн хуралд оролцсон байх -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад холбон зуучилсан байх	Салбар зөвлөлийн хурал нь 2 удаа зохион байгуулагдаж, 26 хүүхдийн асуудлыг хэлэлцэн, халамжийн үйлчилгээг 1 жилээр сунган ажилласан. Зөвлөлийн хурлаар орсон хүүхэд, эцэг эхчүүдэд сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажиллалаа.	100%

3	Хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилготой “Хүүхэд хамгааллын дэлхийн 7 хоног” аяныг зохион байгуулах	-Удирдамж боловсруулан албан байгууллага, аж ахуй нэгж, сумдад хүргүүлсэн байх -Аяны нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулсан байх -Сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байх -Аж ахуй нэгж, хувийн хэвшлийн хүмүүстэй уулзалт, ярилцлага зохион байгуулсан байх -Хүүхдэд ээлтэй аж ахуй нэгжийг шалгаруулах -Хаалтын арга хэмжээг зохион байгуулах	“Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай”, “Хүүхэддээ бахархан дуурайх аав ээж нь байя” сэдэвт аянуудын удирдамж боловсруулан сумдад хүргүүлсэн. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Хүүхдийн эрхийн тухай” хуулиудыг сурталчлах, хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, эцэг эхчүүдэд хүүхдээ зодож шийтгэхгүйгээр өсгөн хүмүүжүүлэх аргыг сурталчлах, хүүхдийн хөгжил хамгаалал, тогтвортой гэр бүл, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчин, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, хүүхэд гэр бүлд зориулсан үйлчилгээг дэмжих, нэвтрүүлэх, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгаалалд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн тэгш оролцоог хангах зорилготой “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” олон нийтийн санаачилгын хүрээнд: 1. “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ-тэй хамтран “Өөдрөг амьдрахуйн нууц” гэр бүлийн сургалтыг өрх толгойлсон 25 эмэгтэй, 16 эрэгтэй, 5 залуу гэр бүл, албан байгууллага, аж ахуй нэгжийн 324 эмэгтэй, 107 эрэгтэйд нийт 482 хүнд зохион байгууллаа. 2. Аймгийн Засаг даргын 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/526 тоот захирамжаар гэр бүлийн уламжлалт ёс заншлыг залуу хойч үеийнхэнд уламжлуулан өвлүүлэх зорилгоор “Тэнгэрлэг гэр бүл”-ийг шалгаруулах журмыг үндэслэн жил бүр аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-үүдийг шалгаруулдаг уламжлалын дагуу сумдаас гэр бүлүүдийн тодорхойлолтуудыг авч нэгтгэн, Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн 5 номинациар гэр бүлүүдийг шалгаруулж, 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдөр буюу “Олон	100%
---	---	---	--	------

			улсын гэр бүлийн өдөр"-өөр алдар гавьяаг нь алдаршуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. 3. "Олон улсын хүүхдийн тусламжийн утасны өдөр"-ийг тохиолдуулан Боловсрол соёл, урлагийн газартай хамтран хүүхдийн тусламжийн 108 утсыг сурталчлах ажлыг аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 19 сургууль, ахлах ангийн нийт 1822 хүүхдийг хамруулан зохион байгууллаа. Тус үйл ажиллагаагаар хүүхдийн санаа бодлыг сонсох, хүүхдэд шаардлагатай сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучлах, бие махбодь, сэтгэцийн эрүүл мэндэд эрсдэлтэй тохиолдолд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилготой "Хүүхдийн тусламжийн 108 утас"-ны талаарх мэдээллийг хүргэлээ. "Хүүхэддээ бахархан дуурайх аав ээж нь байя" аяны хүрээнд: 1."Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хууль, "Хүүхэд хамгааллын тухай" хууль, "Хүүхдийн эрхийн тухай" хууль, "Хамтарсан багийн чиг үүрэг", "Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлцгээе", "Хүүхдийн тусламжийн утас 108", "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр" сургалтуудыг давхардсан тоогоор нийт 1685 иргэн, 2316 хүүхдийг хамруулан зохион байгууллаа. 2. ЕБСургуулийн дунд ангийн сурагчдын дунд "Сэтгэлийн илгээмж" нэртэй гэр бүлдээ зориулан захидал, илгээмж бичих үйл ажиллагааг зохион байгуулан, нийт 42 захидлыг "Хариуцлагатай хамтарсан баг"-ийн гишүүд хаягаар нь хүргэн өгч, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэхэд анхааран ажиллалаа. Эцэг эхчүүд захидлын хариу болох сэтгэлээ хүүхдүүддээ илэрхийлнэ гэдгээ хэлэн,	
--	--	--	--	--

			захидлыг баяртайгаар хүлээн авлаа. 3. 05 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд 1,2-р багийн хөдөөгийн малчин өрхөөр очиж “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиудын гарын авлагыг 80 гаруй айлд тарааж, мэдээлэл өгч ажиллалаа. 4. “Би гэр бүлдээ аз жаргалтай” захидлын уралдааныг нийт ЕБСургуулийн сурагчдын дунд зарлаж, нийт 1545 захидал зураг ирж, захидлыг ээж аавд нь хүргэлээ. 5.Хууль сурталчлах аяны хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль, “Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиар мэдээлэл хийж, хуулийн болон танин мэдэхүйн асуултуудаар “Алтан хонх”, “Дэвжээ” тэмцээнийг 287 иргэнийг хамруулан зохион байгууллаа. 6.“Цахим гадуурхал цаашаа” аяны хүрээнд Сургуулийн нийгмийн ажилтнууд, багш нар, сурагчидтайгаа хамтран “Цахим гадуурхал цаашаа-Эрүүл мэнд наашаа” уриатайгаар дунд ангийн сурагчдыг нэгтгэн, бусдыг уриалсан ханын сонин, лого, боршур, хөдөлгөөнт гимнастикийг хийж, албан байгууллага, дэлгүүрүүдийн гадна иргэд, олон нийтэд түгээн дэлгэрүүлж, сурталчлах ажлыг амжилттай зохион байгууллаа. Тус аяны уралдаанд Вedio бичлэг хийн Facebook хуудас болон олон нийтэд сурталчлан Дундговь аймгийн хэмжээнд тэргүүн байр эзэлж, аймгийн TV-ээр үзэгчдэд хүргэсэн амжилттай байна.	
4	Сумдын хамтарсан багийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж	-Хамтарсан багийн захирамж шинэчлэх -Арга зүйн сургалт зохион байгуулах хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн “Хамтарсан баг байгуулан ажиллуулах тухай” захирамж гаргууллаа. Дэлхийн зөн Дундговь ОНХХ-тэй хамтран сумын түвшинд ажиллаж	100%

	ажиллах	гарсан байх -15 сумын хамтарсан багийн нийт 105 хүнийг оролцуулсан байх	буй хамтарсан багийн гишүүдийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, чадваржуулах зорилготой 2 өдрийн сургалтыг 15 сумын хамтарсан багийн 135 гишүүнийг хамруулан зохион байгууллаа. “Хүүхэд хамгааллын тухай” хууль, “Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор улсын хэмжээний бүх сумдын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах үндэсний хэмжээний сургагч багш Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн оролцоо, иргэний нийгмийн хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Салбарын эрх зүйн зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болормаа, "Монгол өрх" сэтгэл судлалын хүрээлэнгийн үндэсний сургагч багш н.Пагма нар ирж сургагч багшаар ажиллав. Сургалтыг лекц, бүлгийн ажил, хэлэлцүүлэг, оролцооны аргуудыг ашиглан зохион байгуулав. Тус сургалтыг зохион байгуулснаар сумдын хамтарсан баг нь гэр бүл, хүүхдийн эрхийн зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авах, гишүүн тус бүрийн үүргээ ухамсарлан, ойлгож чадсан.	
5	Сумдын хамтарсан багийн гишүүдийн дунд “Дэвжээ” тэмцээн зохион байгуулах	-Сумдад удирдамж гарган хүргүүлсэн байх -15 сумын хамтарсан багийн нийт 105 гишүүнийг хамруулсан байх	Сумдын хамтарсан багуудад “Хариуцлагатай хамтарсан баг” дэвжээ тэмцээний удирдамж боловсруулан хүргүүллээ. “Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар багийн ахлагч, багийн гишүүдийн дунд асуух асуулт бэлтгэж, бэлтгэл ажлыг хангасан.	100%

		-“Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиар асуулт бэлтгэсэн байх	“Дэлхийн зөн Дундговь” ОНХХ-тэй хамтран хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, холбогдох хуульд заасан эрх үүргийг таниулах замаар хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, иргэд олон нийтэд “Хүүхэд хамгааллын тухай” хууль, “Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг сурталчлан таниулах зорилготой “Хариуцлагатай хамтарсан баг” сэдэвт дэвжээ тэмцээнийг зохион байгуулан ажиллав. Дэвжээ тэмцээнд Адаацаг, Өлзийт, Сайнцагаан, Гурвансайхан, Өндөршил, Дэлгэрхангай сумдын хамтарсан багийн гишүүд идэвхи санаачлагатай оролцож, Тэргүүн байранд Өлзийт сумын хамтарсан баг, Дэд байранд Сайнцагаан сумын хамтарсан баг, гуравдугаар байранд Гурвансайхан сумын хамтарсан баг тус тус шалгарлаа. Тус дэвжээ тэмцээнийг зохион байгуулсны үр дүнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай” хууль, “Хүүхдийн эрхийн тухай” хуулийг сурталчлан таниулж, хамтарсан багийн гишүүдийн нэгдмэл байдлыг нэмэгдүүлж чадсан.	
6	Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бүжгийн өдөртэй болох	-Залуучууд хамтран чөлөөт цагаа өнгөрүүлэх, харилцан нөхөрлөх боломж бүрдсэн байх - Залуучуудын бүжгийн өдөртэй болсон байх	Мэргэжлийн бүжгийн багштай хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.	10%

7	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид болон 18-34 насны залуучуудын дунд “Найргийн тэнгэр” яруу найргийн наадмыг зохион байгуулах	-Залуучуудын хөгжлийг дэмжих, тэдний авьяасыг нээн илрүүлэх -“Найргийн тэнгэр” яруу найргийн наадмыг зохион байгуулсан байх	Аймгийн Номын сантай хамтран яруу найргийн наадмыг зохион байгуулахаар хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулсан бөгөөд Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан цаг хугцааны хувьд хойшлоод байна.	30%
8	“Тэнгэрлэг гэр бүл”-ийг журмын дагуу шалгаруулан, алдаршуулах	5 номинацын дагуу аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-үүдийг шалгаруулан, алдаршуулсан байх	Аймгийн Засаг даргын 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/526 тоот захирамжаар батлагдсан аймгийн “Тэнгэрлэг гэр бүл” шалгаруулах журмын дагуу сумдаас ирүүлсэн материалуудыг нэгтгэн, 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл хуралдаж, 5 номинацийн дагуу гэр бүлүүдийг шалгаруулсан. 2017 оны аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-үүдийг алдаршуулах ёслолын үйл ажиллагаа Олон улсын "Гэр бүл"-ийн өдөр болох 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдаж, тэдний хийж бүтээсэн бүтээлүүдийн үзэсгэлэнг гарган, иргэд, олон нийтэд сурталчилж ажиллалаа.	100%
9	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан ХБИ-ийн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сайн үйлсийн өдөрлөгийг зохион байгуулах	-ХБХ-ийн судалгаанаас 50 хүүхдийг сонгон авч, бэлэг гардуулсан байх - ХБХ, эцэг эхэд дэмжлэг үзүүлсэн байх	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2017 оны 5-р сарын 24-нд Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, “Дэлхийн зөн Дундговь” орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, ХБИ-ийн холбоотой хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгууллаа. Өдөрлөг хэлэлцүүлэгт Сайнцагаан сумын хөгжлийн бэрхшээлтэй 50 хүүхэд асран хамгаалагчтайгаа хамрагдлаа. Тус өдөрлөгийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “Эрүүл мэнд” “Боловсролын орчин” “Нийгмийн хандлага” “Дэд	100%

			бүтэц” хүрээнд тулгамдсан асуудлаа ярилцан, “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” хүүхдээ сонсох өдрийн нүүр тулсан уулзалтад оролцох төлөөлөгчийг сонголоо. Мөн хүрэлцэн ирсэн хүүхдүүддээ хүндэтгэл үзүүлж 6-р цэцэрлэгийн бяцхан хүүхдүүд урлагийн тоглолт үзүүлж, “Бүрд” ХХК, “ЭОЖИН” ХХК, “Тогоогийн говь” ХХК, “Өнөмөнх хайрхан” ХХК-иуд оролцогч хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, Хүүхдийн паркийн тоглоомуудад үнэ төлбөргүй тоглууллаа. Үр дүн: Хөжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэн, тэдний дуу хоолойг сонсож, дээрх сэдвүүдийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг гарган нэгтгэж, хүн нэг бүрийн саналыг тусгасан онцлогтой үйл ажиллагаа боллоо.	
10	Паркийн бүх барилга байгууламжид урсгал засвар хийх	-Паркийн барилга байгууламжид шаардлагатай урсгал засвар хийсэн байх - Хүүхдийн паркт хүүхэд, багачууд чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөл сайжирсан байх	Хүүхдийн паркийн бүх барилга байгууламжид урсгал засвар хийж, өнгө үзэмжийг сайжруулан, хүүхэд багачууд чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчинг бүрдүүлэн ажиллалаа.	100%
11	Хүүхдийн паркийн цөөрмийн дотор талын хананы ховхорсон чулууг нөхөж сэлбэх	Ховхорсон чулууг нөхөж, бүрэн тохижуулсан байх	Хүүхдийн паркийн цөөрмийн дотор талын хананы ховхорсон чулууг нөхөн сэлбэж, аюулгүй ажиллагаатай болголоо.	100%
12	Хүүхдийн паркийн тоглоомуудын санамжийг шинэчлэх	Санамжийг шинэчлэн байршуулж, аюулгүй ажиллагааны орчинг бүрдүүлсэн байх	Хүүхдийн паркийн нийт 8 тоглоомын санамжийг шинэчлэн, тоглоом тус бүр дээр байрлууллаа.	100%

13	Хүүхдийн паркийн морин тойруулга руу чулуун зам хийх	Явган хүний зам бүрэн хийгдсэн байх	Хүүхдийн паркийн морин тойруулга руу явсан 42 метр чулуун замыг ажилчдын хүчээр хийж гүйцэтгэлээ.	100%
14	Задгай театр, цэцгийн мандал, сандал, сүүдрэвчнүүдийн өнгө будгийг сэргээх	Гадаад орчны өнгө үзэмж сайжирсан байх	Хүүхдийн паркийн задгай театр, цэцгийн мандал, сандал сүүдрэвчнүүдийн өнгө будгийг сэргээж, хүүхэд багачууд чөлөөт цагаа өнгөрүүлэх ая тухтай нөхцөлийг бүрдүүллээ.	100%
15	Хүүхдийн паркийн алсыг харагчийн кабин бүрийн суудлын бэхэлгээг сайжруулж шинээр хийх	Суудлын бэхэлгээг хийж, аюулгүй байдлыг хангасан байх	Алсыг харагчийн нийт 12 кабинд 24 ширхэг суудлын бэхэлгээг сайжруулж, шинээр хийж, аюулгүй ажиллах боломжийг бүрдүүллээ.	100%
16	Хүүхдийн паркийн мөсөн гулгуурын байшингийн гадна талын өнгөлгөөг хийх	Мөсөн гулгуурын гадна талыг өнгөлсөн байх	Мөсөн гулгуурын байшингийн гадна талд өнгөлгөө хийж, өнгө үзэмжийг сайжрууллаа.	100%
17	Хүүхдийн паркийн 200 мкв талбай бүхий 43 ш мандалд цэцгийн үрсэлгээ хийж, ургацыг 100% хүргэх, цэцгийн нэр төрлийг нэмэгдүүлэх	Цэцгийн мандалд үрсэлгээ хийсэн байх	Хүүхдийн паркийн 43ш цэцгийн мандлын хогийг цэвэрлэн, үрсэлгээ суулгаж, усалгааг тогтмол хийж байна. Тус ажлыг гүйцэтгэхдээ ажил эрхэлдэггүй 5 иргэнийг оролцуулан, нийт 260000 төгрөгийн хөрөнгө зарцууллаа.	100%

18	Бүх модонд тайралт хийж, талбайн мэрэгч устгах хор цацах ажлыг мэргэжлийн хүний зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэх	Паркийн талбайд нийтэд нь мэрэгч устгах хор цацаж, модонд тайралт хийсэн байх	Байгаль орчны газраас мэргэжлийн хүний зөвлөгөө авч, зөвлөгөөний дагуу хүүхдийн паркийн моднуудад тайралт хийлээ. Мэргэжлийн хүний зөвлөгөөний дагуу оготно устгах, хор цацах ажлыг зохион байгууллаа.	100%
19	Галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын бүлгэмийн ажиллах үйл ажиллагааны чиглэлээр ОБХ-ээс сургалт, зөвлөмж авна.	-Байгууллагын ГАУС бүлгэмийн үйл ажиллагааг журмын дагуу бэлэн байдлыг хангуулах -Зөвлөмжийг хэрэгжүүлэн байгууллагын ГАУС бүлгэмийн үйл ажиллагаа тогтмолжсон байх	Хүүхдийн паркийн албан хаагчдад “Галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын бүлгэмийн ажиллах үйл ажиллагааны чиглэл, тоглоомуудын аюулгүй ажиллагааны дүрэм” зэрэг сэдвүүдийн хүрээнд ОБХ-ээс сургалт, зөвлөмж авч ажиллан, байгууллагын галын аюулгүй байдлын бэлэн байдлыг ханган ажиллалаа.	70%
20	Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу зохион байгуулагдаж буй “Хүүхдээ сонсох өдөр”-ийн үйл ажиллагааг зохион байгуулах	4,5,6-р сард төлөвлөгдсөн нүүр тулсан уулзалтуудын бэлтгэл ажил хангагдаж, амжилттай зохион байгуулагдсан байх -Хүүхдийн дуу хоолойг эрх бүхий албан тушаалтнуудад хүргэсэн байх	Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар, “Дэлхийн Зөн Дундговь” орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран хүүхдүүд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах үнэлэлт өгөхөд оролцох, хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах, тэдний нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах зорилготойгоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” нэртэй хүүхдээ сонсох өдөртэй болсон. Тус ажлын хүрээнд ажлын хэсгийн 26 гишүүдийг чадваржуулах “Иргэдийн дуу хоолой түүний үр нөлөө” аргачлал сургалтыг зохион байгуулж, жилийн төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу “Уралдаанч” хүүхэд,	100%

			“СОУЗ”-ийн хүүхэд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдвийн хүрээнд урьдчилсан хэлэлцүүлгийг нийт 282 хүүхдийг хамруулан зохион байгуулж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг гаргаж, СОУЗ-ын хүүхдүүдэд тулгамдаж байгаа асуудлыг удирдах, шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад танилцуулан, нүүр тулсан уулзалтыг хийж, гаргасан саналыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээ.	
21	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, сургалт зохион байгуулах	Төлөвлөгөөг хэрэгжүүлэн сургалт, нөлөөлөл, сурталчилгааны ажлууд хийгдсэн байх	"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг иргэд, олон нийтэд сурталчилах ажлын хүрээнд АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран, "Хүчирхийллийн эсрэг хамтдаа" сарын аяныг зохион байгууллаа. Тус аянаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд сумдын нийгмийн бодлогын 15 мэргэжилтэн, Сайнцагаан сумын 20 иргэн, “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн 50 багш, Хулд сумын 120 иргэнд “Гэр бүлийн хүчирхийлэл”, шинэчлэн батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 гол өөрчлөлт” зэрэг сэдвээр мэдээлэл өгч, 100 ширхэг брошур олшруулан, иргэдэд тараан, мэдээлэл өгч ажиллалаа. ХНХ-ын салбарын харьяа байгууллагуудын нээлттэй өдөрлөгөөр “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан, мэдээлэл	100%

			хийлээ.	
22	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг идэвхижүүлж, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг эерэгжүүлж, гэрч хохирогчийг хамгаалах	-Үйл ажиллагаа сайжирсан байх -Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсан байх - Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа тогтмолжиж, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдүүдийн эрх хамгаалагдсан байна.	Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/67 дугаар захирамжаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 17 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2017 оны ажлын төлөвлөгөөг хорооны даргаар батлуулан төлөвлөгөө, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, ажлын чиг үүрэг”-ийг танилцуулан 3 цагийн сургалт зохион байгууллаа.	100%
23	Байгууллагын албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Байгууллагын албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн чадвар нэмэгдэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг болсон байх	Байгууллагын Архив, бичиг хэргийн ажилтан А.Далайжаргал удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан 8 албан хаагчид “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, төрийн албан хэрэг хөтлөлтийн стандарт” сэдвээр сургалт зохион байгууллаа.	100%
24	Хурдан морины уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах стандарт мөрдүүлж ажиллах, шат дараалсан уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах	-Хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хамгаалалтын хэрэгсэлд хяналт тавьж ажилласан байх -Уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан байх -Уралдаанч хүүхдүүдийн	Хүүхдийн язгуур эрх ашгийг хамгаалах, хэрэгжүүлэх, хүүхдэд тулгамдаж буй асуудлыг цаг тухай бүрд нь шийдвэрлэх зорилгоор Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн №10 тоот тогтоолоор “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” өдрийг сар бүрийн 03-05-ны өдрүүдэд зохион байгуулж байхаар шийдвэрлэсний дагуу 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “Уралдаанч” хүүхдээ сонсох урьдчилсан	100%

		эрх, аюулгүй байдал хангагдсан байх -Уралдаанч хүүхдүүдийн дуу хоолой удирдах түвшний хүмүүст хүрсэн байх	хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт Сайнцагаан сумын 70 уралдаанч хүүхдийн төлөөлөл оролцож, “Уралдаанч” хүүхдүүдийн өмнө тулгамдсан асуудлыг сонсож Монгол улсын MNS6264:2011 хамгаалалтын хувцас, хэлэгсэлд тавигдах стандартад оноо өгөх аргачлалаар үнэлэгээ хийлгэж, цаашид орон нутгийн түвшинд анхаарах, шийдвэрлэх асуудлаа гаргалаа.	
25	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	-Төлөвлөгөөг хэрэгжүүлэн сургалт, нөлөөлөл, сурталчилгааны ажлууд хийгдсэн байх - Төлөвлөгөө батлагдан, төлөвлөгөөний дагуу хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байх	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран баталсан. Тус төлөвлөгөөний дагуу хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготой 2 сарын аяны удирдамж боловсруулан сумдад хүргүүлсэн. Мөн “Хүүхдэд аюултай хөдөлмөр” сургалтыг сумдын нийгмийн бодлогын ажилтнуудад зохион байгуулж, сургалтын багцыг хувилан сумдын хамтарсан багт хүргүүллээ.	70%
26	Хүүхдийн оролцоог дэмжих стратегийг 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	Төлөвлөгөө гаргаж батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байх	Хүүхдийн оролцоог дэмжих стратегийг 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Хүүхдийн оролцооны өөрөө удирдах байгууллагын гишүүдийг чадваржуулах, үйл ажиллагааг идэвхижүүлэх, үр дүнд хүргэх, чиглүүлэгч багш нарт мэдлэг олгох тэднийг чадваржуулах зорилгоор “Оролцоод хөгжье” багц сургалтыг “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ-тэй хамтран ЕБС-ийн нийгмийн ажилтнууд, оролцооны бүлгийн	100%

			хүүхдүүд нийт 30 хүнд, "Би том гартай ч хүчирхийлэгч биш" сургалтыг Аймгийн хүүхдийн 11-р чуулганы төлөөлөгч 143 хүүхэд, аймгийн Засаг даргын "Хүүхдээ сонсох өдөр" аяны хүрээнд тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг гаргаж, СОУЗ-ын хүүхдүүдэд тулгамдаж байгаа асуудлыг удирдах, шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад танилцуулан, нүүр тулсан уулзалтыг хийж, гаргасан саналыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн. АХНЗ-ийн 35 гишүүнийг чадваржуулах сургалт, туршлага солилцох уулзалтыг тус тус зохион байгуулсан.	
27	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах	-Үйл ажиллагаа зохион байгуулагдсан байх -Удирдамж төлөвлөгөө гарсан байх - Батлуулсан төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн байх	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Жаргалтай гэр бүл", "Хүчирхийллийн эсрэг хамтдаа" гэсэн 2 төрлийн аян зохион байгуулах тухай удирдамж төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллалаа. Тус аянуудын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, Шинэчлэн батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 10 гол өөрчлөлт" сэдвүүдээр 245 иргэнд мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан ба гэр бүлийн 8 модуль сургалтаар дамжуулан гэр бүлийн гишүүн бүрт гэр бүлийн боловсрол олгож, гишүүн бүрийг хариуцлагажуулж чадсан үр бүтээлтэй ажил боллоо.	100%
28	"Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих", "Залуучуудын хөгжил оролцоог дэмжих" аймгийн дэд хөтөлбөр	-Хөтөлбөрүүд батлагдаж, хэрэгжиж эхэлсэн байх - Гэр бүл, залуучуудын хөгжил хамгаалал	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээнд тухайн заалтыг тусгуулж, Гэр бүлийн хөгжлийг дэмжих, залуучуудын оролцоог хангах үндэсний хөтөлбөрийн төсөлтэй уялдуулан, "Гэр	30%

	хэрэгжүүлэх	сайжирсан байх	бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг батлуулахаар төсөл хэлбэрээр бэлтгээд байна.	
29	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, нээлттэй байдал, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн баримтад дотоод хяналт шалгалт хийж, зөвлөмж боловсруулах	-Дотоод хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмж гарсан байх - Дотоод хяналт шалгалтын үр дүнд үндэслэн үйл ажиллагаа сайжирсан байх	Газрын дотоод хяналт шалгалтын нэгжийн 2017 онд зохион байгуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу удирдамж боловсруулан, газрын даргаар батлуулан 2017 оны 06 дугаар сарын 05-09-ны өдрүүдэд 1. Хүүхдийн паркийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, зарцуулалт 2. Шилэн дансны хуулиар мэдээлэгдэх заалтууд орсон эсэх, мэдээлэл хуульд заасан цагалбарын дагуу оруулсан эсэх 3. E-office-Able программын хэрэглээ, уг программд ажлын төлөвлөлт ямар байгаа 4. Хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт 5. Байгууллагын цахим сайтын мэдээлэл 6. Залуучуудын хөгжлийн албаны үйл ажиллагааны хэрэгжилт 7. Албан хэрэг хөтлөлтийн стандарт 8. Мэдээллийн ил тод байдал, мэдээллийн самбарын ашиглалт, мэдээллийн чанар хүртээмжийн байдал зэрэгт хяналт шалгалтыг зохион байгуулж, хяналт шалгалтын тайланг байгууллагын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулан, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.	100%
30	Хүүхэд харах үйлчилгээний үйл явцад тогтмол хяналт шалгалт, сургалт нөлөөллийн	-Үйл ажиллагаа сайжирсан байх -Эцэг эхээс санал асуулга авсан байх	Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/174 тоот	100%

	ажлыг зохион байгуулах	-Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьсан байх - Хүүхэд харах үйлчилгээний стандарт хангагдсан байх	тушаалаар батлагдсан "Хүүхэд харах үйлчилгээнд хяналт, шалгалт хийх ажлын удирдамж", ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн тушаалаар баталсан удирдамж, 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/152 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсэг Дундговь аймгийн Сайнцагаан суманд "ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭ" эрхэлж буй иргэн С.Өлзийдүүрэнгийн үйл ажиллагаа, үйлчилгээнд 2 удаа хяналт, шалгалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.	
31	Албан хаагч бүр байгууллагын орчинд болон нийтийн эзэмшлийн талбайд 1-ээс доошгүй мод тарих, байгууллага бүр 10м ² зүлэг, 10м ² цэцгийн мандал мөн батлагдсан загварын дагуу тус бүр 2 ширхэг хогийн сав хийж, БОАЖГазарт актаар хүлээлгэж өгөх	-БОАЖГазарт актаар хүлээлгэн өгч, гарын үсэг зурж баталгаажуулсан байх -Ургалт 85-аас дээш хувьтай байх	Байгууллагын албан хаагчид байгууллагын гадна хайсанд 100ш хайлаас мод тарьж, 3ш цэцгийн мандалд үрсэлгээ суулган, нийт 180000 төгрөг зарцуулсан байна. Байгууллагын гаднах хогийн сав, хайсыг будаж өнгө оруулсан.	100%
Хэрэгжилтийн дундаж хувь				89.6%

Хэрэгжилт гаргасан:

Ахлах мэргэжилтэн Ц.Энхбилгүүн

Хянасан:

Дарга Ц.Ганзориг